



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ  
ГАЗАР**

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Партизаны гудамж, Утас: 26 35 64, Факс: (976) 32 49 77,  
E-mail: doc@nema.mn; http://www.nema.gov.mn

2018.03.13 № 7/527

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Санал авах тухай**

Галын аюулгүй байдлын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, гал түймрийн улсын хяналт, хяналтын байцаагчийн бүрэн эрх, авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн “Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн дундаж үзүүлэлтийг дүгнэх журам”-ыг шинэчлэн боловсруулаад байна.

Иймд тус “Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажил дүгнэх журам”-ын төсөлтэй танилцаж, саналаа 2018 оны 03 дугаар сарын 16-ны дотор албан бичгээр болон цахимаар ирүүлнэ үү.

Журмын төслийг [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn) сайтын Хууль эрх зүй цонхонд байршуулсан.

Харилцах утас, и-мэйл: 263545, 263546, [hyanaltiinheltes.obeg@yahoo.com](mailto:hyanaltiinheltes.obeg@yahoo.com)

ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА



Ц.НЯМБАЯР

00000451

# ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ ЖУРАМ

## Нэг. Зорилго

1.1.Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагын гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын байрны тодорхойлтод заасан чиг үүргийн хүрээнд гал түймрийн улсын хяналтыг зохион байгуулах, үр дүнг нэгтгэн дүгнэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

1.2.Гал түймрийн улсын хяналтын байцаагч энэхүү журмыг дагаж мөрдөнө.

## Хоёр. Зохион байгуулалт

2.1.Аймаг, нийслэлийг хүн ам, барилга байгууламжийн төвлөрлөөр нь дөрвөн бүсэд хуваана.

2.1.1.нийслэлийн бүс: /Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг/,

2.1.2.нэгдүгээр бүс: /Дархан-Уул, Дорнод, Орхон, Сэлэнгэ аймаг/,

2.1.3.хоёрдугаар бүс: /Архангай, Булган, Дорноговь, Завхан, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн Багануур, Налайх дүүрэг/,

2.1.4.гуравдугаар бүс: /Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Увс, Төв, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, нийслэлийн Багахангай дүүрэг/

## Гурав. Сард хийсэн байвал зохих ажил

3.1.Гал түймрийн онц аюултай, гал түймрийн аюултайн I, II, III зэргийн объектод галын аюулгүй байдлын төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг нийслэлийн бүсэд 60, нэгдүгээр бүсэд 45, хоёрдугаар бүсэд 35, гуравдугаар бүсэд 25-н иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламжид хийж, шалгасан байгууллагын 80-аас доошгүй хувьд заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдэл, танилцуулга, дүгнэлт, акт зэргийг гаргаж өгсөн байна.

3.2.Гал түймрийн хэрэг, зөрчлийг хянаж шийдвэрлэх, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирсэн өргөдөл гомдол, санал, хүсэлтийг хуулийн хугацаанд нь зохих журмын дагуу шийдвэрлэн бүртгэл хөтөлсөн байна

3.3.Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг удирдамжийн дагуу цаг хугацаанд нь хийж, илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулна.

3.4.Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

3.5.Байцаагчийн хөтлөвөл зохих бүртгэл, судалгаатай байна.

3.5.1. төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалт,

3.5.2.байцаагчаас гаргасан эрх зүйн баримт бичиг,

3.5.3.зөрчил шалган шийдвэрлэсэн,

3.5.4.гал түймрийн хэрэг, зөрчил,

3.5.5.барилга, байгууламж,

3.5.6.барилга байгууламжийн зураг хяналт, улсын комисст ажилласан,

3.5.7.галын аюулгүй байдлын дүгнэлт олгосон

3.6.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний Цахим бүртгэлийн санд мэдээ оруулсан байна.

### **Дөрөв. Дүгнэх аргачлал**

4.1.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлыг сар бүрийн 25-ны дотор газар, хэлтсийн дарга нар дүгнэж, дүнг албажуулан 28-ны дотор ОБЕГ-ын ГТТГ-ын гал түймрийн улсын хяналтын хэлтэст [hyanaltiinheltes.obeg@yahoo.com](mailto:hyanaltiinheltes.obeg@yahoo.com) хаягаар ирүүлнэ.

4.2.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлыг дүгнэх үзүүлэлт /Y1, Y2, Y3, Y4/

4.3.Хяналт шалгалтын ажил дүгнэх / Маягт 1/

4.3.1.төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтад хамрагдсан нийт барилга байгууламж хамаарна.

4.3.2.шалгасан нийт барилга байгууламжийн 80-аас дээш хувьд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрх зүйн баримт бичиг бичиж өгнө.

4.3.3.төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсний дараа хуулийн хугацаанд эрх зүйн баримт бичиг бичиж өгсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад заавал гүйцэтгэлийн шалгалтыг зохион байгуулна.

4.3.4.гүйцэтгэлийн шалгалтын шалгасан объектыг тооцохдоо иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эрх зүйн баримт бичиг бичиж өгсөн актаас тооцно.

4.3.5.зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэсэн хувийг байцаагчаас бичсэн эрх зүйн баримт бичгээс хамааруулж тооцно.

4.4.Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хийсэн ажлыг дүгнэх үзүүлэлт / Маягт 2 /

4.4.1.хяналт шалгалтын ажлыг дүгнэхдээ Маягт 1-т гарсан нийт хувийг тавьж, Y1-д заасан оноогоор,

4.4.2.нэгдсэн арга хэмжээ, мэдээ, тайлан ирүүлсэн байдлыг дүгнэхдээ Y2-т заасан оноогоор,

4.4.3.цахим бүртгэл мэдээллийн санд мэдээ оруулсан байдлыг Y3- т заасан оноогоор,

4.4.4.гал түймрийн хэрэг, зөрчлийн шийдвэрлэлтийг Y4- т заасан оноогоор тус тус дүгнэнэ.

4.5.Нийслэлийн Багануур, Налайх дүүргийг хоёрдугаар бүсэд, Багахангай дүүргийг гуравдугаар бүсэд оруулж дүгнэнэ.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ ДҮГНЭХ

МАЯГТ 1

Аймаг, Нийслэл	Байцаагчийн цол, овог нэр	Сарын ажлын дундаж үзүүлэлт												Нийт %	
		Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт			Зөрчил			Эрх зүйн баримт бичиг /шалгасан объектын 80%-д/			Гүйцэтгэлийн шалгалт		Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэсэн байдал		
		Шалгавал зохих объект	Шалгасан объект	%	Илрүүлсэн	Арилгуулсан	%	Бичвэл зохих	Бичсэн	%	Шалгасан объект	%	Удаа	%	
Улаанбаатар															

ДҮГНЭСЭН: ДАРГА,  
/...../

**ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ХИЙСЭН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

**МАЯГТ 2**

	Байцаагчийн цол, овог нэр	Хяналт шалгалтын ажил %	Оноо /40/	Нэгдсэн арга хэмжээ %	Оноо /10/	Мэдээ, тайлан ирүүлсэн байдал %	Оноо /10/	Цахим бүртгэлийн санд мэдээ оруулсан байдал %	Оноо /25/	Гал түймрийн хэрэг, зөрчлийн шийдвэрлэлт %	Оноо /15/	Нийт оноо	Үнэлгээ
		<b>1</b>		<b>2</b>		<b>3</b>		<b>4</b>		<b>5</b>			
Улаанбаатар													

ДҮГНЭСЭН: ДАРГА,  
/...../



**ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН  
БАЙЦААГЧИЙН АЖЛЫГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ**

Ү1

Хяналт шалгалтын ажил		
№	Хувь	Оноо
1	20-30	5
2	30-40	10
3	40-50	15
4	50-60	20
5	60-70	25
6	70-80	30
7	80-90	35
8	90-100	40

Ү2

Нэгдсэн арга хэмжээ, мэдээ тайлан ирүүлсэн байдал		
№	Хувь	Оноо
1	50-60	2
2	60-70	4
3	70-80	6
4	80-90	8
5	90-100	10

Ү3

Цахим бүртгэлийн санд мэдээ оруулсан байдал		
№	Хувь	Оноо
1	50-60	5
2	60-70	10
3	70-80	15
4	80-90	20
5	90-100	25

Ү4

Гал түймрийн хэрэг, зөрчлийн шийдвэрлэлт		
№	Хувь	Оноо
1	60-70	5
2	70-80	10
3	80-90	15
4	90-100	20

90-100 оноо авсан бол “А” буюу “Машсайн”;  
80-90 хүртэл оноо авсан бол “В” буюу “Сайн”  
70-80 хүртэл оноо авсан бол “С” буюу “Хангалттай”;  
60-70 хүртэл оноо авсан бол “D” буюу “Дутагдалтай”;  
50-60 хүртэл оноо авсан бол “F” буюу “Хангалтгүй”.